



Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахтай холбоотой Монгол дахь үйл ажиллагаа

Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний бодлого

Нэр	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УАӨҮХ)
Зорилт	<ul style="list-style-type: none"> ● Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах ● Эдийн засаг, нийгмийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх ● Эмзэг байдал, эрсдлийг бууруулах ● Үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хий (ХХ)-н ялгаралтыг бууруулах ● Ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
Хэрэгжих хугацаа	1 дүгээр үе шат: 2011-2016, 2 дугаар үе шат: 2017-2021
Нэр	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр 2005-2020
Зорилт	<ul style="list-style-type: none"> ● 2020 он гэхэд нийт эрчим хүчний үйлдвэрлэл дэх сэргээгдэх эрчим хүчний хувь хэмжээг 20-25 %-д хүргэх ● 2020 он гэхэд системийн алдагдлыг 10-аас доошгүй %-иар бууруулах /2005 онтой харьцуулахад/
Нэр	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2010-2016
Зорилт	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 2012 он гэхэд 30 %, 2016 он гэхэд 50 %-иар бууруулах
Суурь он	2010

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахтай холбоотой хуулиуд

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль (2007 оны 1 сарын 11)

- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг зохицуулсан
- Сэргээгдэх эрчим хүч ашиглан үйлдвэрлэж нийлүүлсэн цахилгаан эрчим хүчинд төлөх үнэ тарифийг тогтоосон

Агаарын төлбөрийн тухай хууль (2010 оны 6 сарын 24)

- Агаарын бохирдолын төлбөр ногдуулах зүйлс, төлбөрийн хувь хэмжээ, хуулийг дагаж мөрдөөгүй тохиолдолд ногдох шийтгэл зэргийг тогтоосон.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Агаарын тухай хууль

(шинэчлэн боловсруулсан хууль 2010 оны 6 сарын 24-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн)

- Агаарын чанарыг хамгаалахад болон агаарын бохирдлыг бууруулахад холбогдох байгууллагуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ийн суурь конвенц (НҮБУАӨСК), түүний Киотогийн протоколын хүрээнд Монгол улсын хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаар бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий УУӨЗА-ыг байгуулж ажиллахыг БОАЖЯ-нд үүрэг болгосон байна.

ХХ-ийн Ялгаралтыг Бууруулах Зохистой Арга Хэмжээ (ХХЯБЗАХ)

НҮБУАӨСК-д өргөн
мэдүүлсэн огноо

Хэвлэгдсэн
огноо

2010 оны 1 сарын 28

Бүтэц зохион байгуулалт

(1) Байгууллагын бүтэц

Эх сурвалж: БОАЖЯ

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ийн суурь конвенц болон түүний Киотогийн протоколын хүрээнд Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндэсний бодлого хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой салбар дундын бодлого үйл ажиллагааг зохицуулах

Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороо

Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)

- **Дарга:** Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудал хариуцсан удирдах байгууллага
- Доорх асуудлыг хариуцна:
 - уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үндэсний бодлого хөтөлбөрийг батлах
 - төслүүдийг үнэлэх
 - эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд заавар, зөвлөмж өгөх

Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах алба (УАӨЗА)

ЦХМ-ын үндэсний товчоо (ЦХМ-ҮТ)

Ногоон өсөлтийн хороо

(2) Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УАӨҮХ)

Эх сурвалж : БОАЖЯ

Стратеги зорилт

1. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх;
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, байгаль орчны тэнцвэрт байдлыг ханган, эдийн засаг, нийгмийн эмзэг байдал, эрсдэлийг үе шаттайгаар бууруулах;
3. Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулж, карбон багатай эдийн засагт шилжих эхлэлийг тавих /үүнд “карбон багатай эдийн засаг” гэж хүлэмжийн хийн ялгаралт багатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явдал давамгайлсан эдийн засгийг хэлнэ/;
4. Уур амьсгалын ажиглалтын сүлжээг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, судалгаа, шинжилгээ, үнэлгээний ажлыг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;
5. Олон нийтийг уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллийг хүн амд өгөх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх.

1-р үе шат (2011-2016)

- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлэх.
- Эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэх.
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.

2 – үе шат (2017-2021)


- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хүлэмжийн хийн ялгаралтын өсөлтийг сааруулах үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх.

Холбогдох салбар байгууллагууд

- Санхүү
- Эдийн засаг
- Гадаад харилцаа
- Хүнс, хөдөө аж ахуй
- Аж үйлдвэр
- Эрдэс баялаг эрчим хүч
- Тээвэр, барилга ба хот төлөвлөлт
- Эрүүл мэнд
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан


ХХЯБЗАХ-ний тухай мэдээлэл

ХХ-н ялгаралт (2006)



*ГАГАӨ-Газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт

Хөдөө аж ахуйн салбар



Эрчим хүчний салбар



Эх сурвалж: НҮБҮАӨСК-ийн газарт өргөн мэдүүлсэн Монголын 2 дахь илтгэл (тайлан) <http://unfccc.int/resource/docs/natc/mongnc2.pdf>

Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зохистой арга хэмжээ (ХХЯБЗАХ)

Эх сурвалж: НҮБҮАӨСК http://unfccc.int/meetings/cop_15/copenhagen_agreement/items/5265.php

№	Салбар / үйл ажиллагаанууд	Үйл ажиллагааны хэлбэрүүд
1	Эрчим хүчний нийлүүлэлт-Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	
а	PV болон нарны эрчим хүчээр дулаан үйлдвэрлэх	Говийн бүсэд том хэмжээний PV системүүдийг суурилуулах
б	Салхин эрчим хүч үйлдвэрлэл болон салхин паркууд	<ul style="list-style-type: none"> Өмнөд бүсийн аймгийн төвүүдэд 100-150 квт-ын чадалтай салхин турбинуудыг байрлуулах Том хэмжээний салхин цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх
в	Усан Цахилгаан станц	Жижиг болон дунд чадлын усан цахилгаан станц ашиглахыг хөхүүлэн дэмжих
2	Эрчим хүчний нийлүүлэлт- Нүүрсний чанарыг сайжруулах	
а	Нүүрсний хүдрийг баяжуулах	Таван Толгой, Шивээ Овоо, Бага Нуур гэх зэрэг томоохон нүүрсний уурхай дээр нүүрс угаах технологи нэвтрүүлэх
б	Нүүрсээр шахмал түлш үйлдвэрлэх	Нүүрсээр шахмал түлш үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх
3	Эрчим хүчний нийлүүлэлт- Халаалтын зуухны үр ашгийг сайжруулах	
а	Өндөр үр ашигтай, шинэ загвар бүхий халаалтын зуух суурилуулах болон одоо байгаа халаалтын зуухнуудын үр ашгийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> 25 МВт-ийн үр ашиг өндөртэй зуухнуудыг хэрэглэх x12 1 МВт-ийн шинэ зуухнууд суурилуулах x260
б	Усан халаагуурын зуухнуудыг бага чадлын дулааны станц болгон өөрчлөх	Уурын зуухнуудыг 10 МВт-ийн хүчин чадалтай дулааны станц болгон өөрчлөх x5

№	Салбар / үйл ажиллагаанууд	Үйл ажиллагааны хэлбэрүүд
4	Эрчим хүчний нийлүүлэлт- Айл өрхийн зуух, пийшинг сайжруулах	
а	Айл өрхийн пийшин, зуухны түлшийг солих	Хотын айл өрхийн зууханд ашиглагдаж буй түүхний нүүрсийг хийн түлш, шахмал түлшээр солих
б	Айл өрхийн зуух, пийшингийн хийц загварыг сайжруулах, шинэчлэх	Айл өрхийн пийшэн болон зуухыг шинэчлэх х250
5	Эрчим хүчний нийлүүлэлт- Дулааны станцуудыг сайжруулах	
	Үр ашигийг нэмэгдүүлж дотоод хэрэглээг бууруулах	<ul style="list-style-type: none"> ● Дулааны станцуудын үр ашигийг сайжруулах ● Дулааны станцуудын эрчим хүчний дотоод хэрэглээг бууруулах
6	Эрчим хүчний нийлүүлэлт– Хотын айл өрхийн халаалтанд цахилгааны хэрэглээг нэмэгдүүлэх	
	Хотод айл өрхийн дулаан хангамжинд цахилгаан хэрэглэдэг болох	Улаанбаатар хотын дүүргүүдийн гэр хороололын айл өрхүүдийн дулаанд цахилгаан эх үүсвэр ашиглахыг нэмэгдүүлэх
7	Барилга – Барилгын эрчим хүчний үр ашгийг сайжруулах	
а	Барилгын дулаан хангамжыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ● Дулаан үйлдвэрлэл дэх алдагдлыг бууруулах ● Өрөөний температурыг зохицуулах
б	Орон сууцнуудад халуун ус болон халаалтыг хэмжих төхөөрөмжийг суурилуулах	Дулааны үнэ, төлбөрийг тооцох боломж олгох дулааны хэрэглээг бодитоор хэмжих төхөөрөмжүүдийг орон сууцнуудад суурилуулах
в	Одоо байгаа барилгуудын дулаалгыг сайжруулах, шинээр баригдах барилгуудад эрчим хүчний үр ашгийн шинэ стандарт мөрдүүлэх	Байшин болон орон сууцны эрчим хүчний үр ашгийг одоогын байгаа түвшингээс 2-3 дахин сайжруулах
г	Барилгын гэрэлтүүлгийн үр ашгийг сайжруулах	Байгууллагын болон орон сууцны барилга байгууламжын улайсдаг чийдэнг эрчим хүчний хэмнэлттэй гэрэл чийдэнгээр солих
8	Аж үйлдвэр– Аж үйлдвэрийн эрчим хүчний үр ашгийг сайжруулах	
а	Хэрэглээний дадал зуршлыг сайжруулах	Дотоод эрчим хүчний хэрэглээний зөв менежменттэй болох
б	Хөдөлгүүрийн үр ашгийг сайжруулах	Эрчим хүчний үр ашигтай хөдөлгүүр, тоног төхөөрөмж: хурдны тохируулгатай хөдөлгүүр суурилуулах; үйл ажиллагааны арга барилыг сайжруулах, хүчин чадлын хэмжээг оновчтой болгох, механик эрчим хүчний дамжуулалтыг сайжруулах, бусад тоног төхөөрмжийн үр ашгийг сайжруулах
в	Цементийн үйлдвэрлэлд хуурай аргыг нэвтрүүлэх	Цемент үйлдвэрлэх нойтон арга технологийг хуурай арга технологиор солих
9	Тээвэр	
	Түлшний зарцуулалт багатай тээврийн хэрэгсэл ашиглах	<ul style="list-style-type: none"> ● Эрчим хүчний үр ашигтай тээврийн хэрэгслийн импортыг хөхүүлэн дэмжих зорилгоор хуучин автомашин импортлох стандартыг мөрдүүлэх ● Тээврийн хэрэгслийн үр ашгийг сайжруулах зорилгоор тээврийн хэрэгслийн бүртгэлийн татварыг бий болгож хэрэгжүүлэх

№	Салбар / үйл ажиллагаанууд	Үйл ажиллагааны хэлбэрүүд
10	Хөдөө аж ахуй	
	Малын ялангуяа үхрийн ашиг шимийг нэмэгдүүлэх замаар нийт малын тоо толгойг хязгаарлах	<ul style="list-style-type: none"> Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх дэд бүтэц бий болгох, эдийн засгийн орчныг бүрдүүлэх Нийгмийн хэрэгцээнд тулгуурлан мал үржүүлгийг чанаржуулах, сайжруулах Мал эмнэлгийн үйлчилгээг олон улсын стандартад хүргэх Малын байгаль, экологи, цаг уурын өөрчлөлтөд эмзэг байдлыг бууруулах, амьдрах чадварыг сайжруулах Мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлийг хөгжүүлэх, эдийн засгийн эргэлтийг хурдасгах
11	Ой	
a	Ойн менежментийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Байгалийн нөхөн сэргэлт Ойжуулалт Мод үржүүлэг Хамгаалалтын бүс Био цахилгаан
б	Ой усталт, ойн доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, ойн тогтвортой менежментийг бий болгох, Монголын ойд агуулагдаж буй нүүрсхүчлийн хуримтлалыг нэмэгдүүлэх	Орон нутгийн нөхөрлөлд тулгуурласан ойн менежментийг бий болгох, ойжуулалт хийх, ойн нөөцийн тогтвортой хэрэглээг бий болгох замаар РЭДД буюу ой устгах, доройтохоос сэргийлэх арга хэмжээ авч хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулан нүүрстөрөгчийн санхүүжилт авах

ЦХМ-ын мэдээлэл

(1) Монгол дахь ЦХМ-ын өнөөгийн байдал

ЦХМ-ын үндэсний товчоо нь БОАЖЯ-ны харьяа 2004 оны 11 сард байгуулагдаж НҮБУАӨСК-ийн нарийн бичгийн газарт албан ёсоор бүртгүүлсэн. ЦХМ-ын үндэсний товчоо нь ЦХМ-ын төслүүдэд батламж болон зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагааг зохицуулж байна. 2011 оны 6 сарын 28-нд БОАЖ-ын сайдын тушаалаар ЦХМ-ын төсөл үнэлэх журам, үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн баталсан.

2011-2021 оны хооронд хэрэгжүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг УИХ-аар 2011 оны 1 сарын 6-нд баталсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохицуулах үүрэг бүхий уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах албыг БОАЖЯ-ны харьяа 2011 оны 2 сарын 1-нд байгуулаад байна. ЦХМ-ын үндэсний товчоо нь 2010 оны 6 сарын 24-нд батлагдсан Агаарын тухай хуулийн дагуу энэхүү зохицуулах албаны бүтцэд харьяалагдах болсон.

Ерөнхий мэдээлэл (2011 оны 11 сар)

Төслийн өнөөгийн байдал	Тоо.
ЦХМ-ын гүйцэтгэх зөвлөлд бүртгэгдсэн төсөл	3
Батламж бичиг авсан төсөл	6
Магадлагаа хийлгэсэн юмуу хийлгэж буй төсөл	2

Эх сурвалж: IGES CDM Project Database http://www.iges.or.jp/en/cdm/report_cdm ЦХМ-ын үндэсний товчоо: <http://www.cdm-mongolia.com>

Бүртгэгдсэн төслүүдийн үндсэн мэдээлэл (2011/11 сарын байдлаар)

	ЦХМ-ын бүртгэгдсэн төсөл					Буцаагдсан
	Төслийн тоо	Нэг жилд бууруулах дундаж (тн CO ₂)	2012 он хүртэл нийт бууруулах хэмжээ(тнCO ₂)	Олгогдсон ЯББ (тн CO ₂)	Шинэчлэгдсэн	
Усан цахилгаан станц	2	30,000	302,173	15,354	0	0
Эрчим хүчний үр ашиг	1	11,904	83,328	0	0	0
Нийт	3	23,968*	385,501	15,354	0	0

Эх сурвалж: IGES CDM Project Database http://www.iges.or.jp/en/cdm/report_cdm.html

*Нийт төслийн жилийн дундаж ялгаралтын бууралт

(2) ЦХМ-ын төслийн мэдээлэл

Батламж бичиг авсан болон бүртгэгдсэн төсөл (2011/11 сарын байдлаар)

ЦХМ-ын төслийн нэр	Төслийн төрөл	Нэмэлт мэдээлэл	Батламж бичиг авсан (Он/Сар/өдөр)	Жилд бууруулах хэмжээ (тн CO2/жил)	Төсөлд оролцогч (Төсөл хэрэгжиж буй орны)	Төсөлд оролцогч (Бусад)	Өнөөгийн байдал
Дөргөний усан цахилгаан станц	Усан цахилгаан станц	Шинэ далан	2006/10/2	30,400	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг эрчим хүчний газар	Mitsubishi UFJ Securities Co., Ltd.	14,468 тCO2-той тэнцүү хэмжээний ЯББ олгогдсон
Тайширийн усан цахилгаан станц	Усан цахилгаан станц	Шинэ далан	2006/10/02	29,600	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг эрчим хүчний газар	Mitsubishi UFJ Securities Co., Ltd.	2 удаагийн олголтоор 886т CO2-той тэнцүү хэмжээний ЯББ олгогдсон
Төвлөрсөн бус уурын зуухнуудын техник, технологийг сайжруулах	Эрчим хүчний үр ашиг	Нийлүүлэлт т талын	2006/04/27	11,904	Прокон Норд Эрчим хүчний систем GmbH Монгол зуух ХХИ ХХК.		Бүртгэгдсэн
Салхитийн салхин парк	Салхин эрчим хүч	Нийт 50 МВт	Батламж бичгийг шинэчлэн олгосон 2011/11/11	180,960	Клин Энержи ХХК, Монгол		Магадлагаа хийлгэж байгаа
Майхан усан цахилгаан станц	Усан цахилгаан станц	Урсацаар	2010/12/09	36,377	Усны эрчим ХХК		Магадлагаа ны өмнөх үе шатан дээр байгаа
Монгол дахь Пеллет ба Брикетиин Үйлдвэр	Биомасс	Бусад	2011/03/21	19,436	Эн Ти Ай Си ХХК (Шинэ технологи, хөрөнгө оруулалт болон зөвөлгөө) групп	EnBW Trading GmbH	Магадлагаа хийлгэж байгаа

Бүтэц зохион байгуулалт, журам, шалгуур үзүүлэлт

(1) Товчооны бүтэц

ЦХМ-ын үндэсний товчоо(ЦХМ ҮТ)

Орон тооны бус шинжээчдийн баг

ЦХМ-ын төсөл үнэлэх ҮХ

Дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Нарийн бичиг: ЦХМ-ын үндэсний товчооны дарга

Гишүүд:

Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн яам

Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам

Сангийн яам

Зам тээвэр, барилга хот

байгуулалтын яам

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар

Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо

Нийслэлийн засаг даргын тамгын газар

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим

Эрчим хүчний ассоциаци

Монгол улсын их сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

ЦХМ-ын үндэсний товчооны үүрэг

- I. ҮХ-ны хурал зохион байгуулах;
- II. Шинжээчдийн багийг томилох;
- III. ЦХМ-ын төсөл боловсруулагчдад батламж болон зөвшөөрлийн бичиг олгох;
- IV. Батламж бичиг олгогдсон төслүүдийн үйл явцыг хянах;
- V. Монголд хэрэгжиж буй ЦХМ-ын төслүүдийг бүртгэх;
- VI. Техникийн багт болон төсөл боловсруулагчид, олон нийтэд зөвлөгөө өгч, мэдээлэл түгээх;
- VII. ЦХМ-тай холбоотой үндэсний бодлого, дүрэм, журмыг боловсруулах;

ЦХМ-ын төсөл үнэлэх ҮХ-ны үүрэг

- I. ЦХМ-ын төслүүдийг тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэн үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд хэр нийцэж байгаа зэрэгт үндэслэн батламж болон зөвшөөрлийн бичиг олгох эсэхийг шийдвэрлэх.

Орон тооны бус шинжээчдийн багийн үүрэг

- I. Аливаа төсөл нь ЦХМ-ын төслүүдэд тавигддаг тодорхой байгаль орчны болон техникийн шаардлагыг хангасан эсэхийг шинжилж нягтлах.

(2) Төсөл үнэлэх журам


Зөвшөөрлийн бичиг авахаар төсөл боловсруулагч дараах материалыг бүрдүүлж өгөх шаардлагатай.

- 1 Зөвшөөрлийн бичиг авах хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг (Монгол хэл дээр гарын үсэг зурж баталгаажуулсан эх хувиар)
- Төслийн санал бичиг (ТСБ)-ийг Англи хэл дээр 2 хувь мөн электрон хувилбараар
- Зөвшөөрлийн бичгийн зорилго, утга, зөвшөөрлийн бичиг авснаар хүлээж буй үүрэг хариуцлагаа бүрэн ойлгож ухамсарлаж буй талаар гарын үсэг зурж баталсан мэдэгдэл

Зөвшөөрлийн бичиг олгох үйл явц:

- 1 Товчоо нь зөвшөөрлийн бичиг хүссэн албан бичиг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг шалгана. Бүрэн бол Үнэлгээний Хороо (ҮХ)-ны гишүүдэд хүргүүлэн ТСБ-ийг өөрийн цахим хуудсандаа хоёр 7 хоногийн хугацаатай байршуулна.
- 2 Олон нийтээс санал, шүүмжлэл ирүүлсэн бол түүнийг нэгтгэн үнэлгээний хорооны гишүүдэд хүргүүлнэ.
- 3 Товчоо төсөл боловсруулагчдад зөвшөөрлийн бичиг олгох эсэх талаар үнэлгээний хорооны шийдвэрийг үнэлгээний явцад төсөл боловсруулагч асуултад хэр хурдан хариу өгч байгаагаас шалтгаалан ажлын 30 хоногт батгаан мэдэгдэнэ.
- 4 !!! Зөвшөөрлийн бичиг нь батламж бичгийг орлохгүй бөгөөд төслийн баримт бичиг боловсруулагдсаны дараа төсөлд оролцогчид батламж бичиг авахаар төслөө өргөн мэдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Зөвшөөрлийн бичиг олгох үйл явц (сайн дурын)



Төсөл боловсруулагч нь батламж бичиг авахаар дараах материалуудыг бүрдүүлж өгнө:


- 1 Батламж бичиг авах хүсэлтээ илэрхийлсэн албан бичгийг Монгол, Англи хэл дээр үйлдэн ЦХМ-ын төсөлд оролцогчид (оролцогч байгууллагыг төлөөлөх эрх бүхий хүн) гарын үсэг зурж баталгаажуулсан эх хувь
- ЦХМ-ын гүйцэтгэх зөвлөлөөс баталсан тухайн төсөлд хамаарах маягтын дагуу Англи хэл дээр бэлтгэсэн төслийн баримт бичиг-ТББ (хэвлэмэл хоёр, электрон нэг хувийг өргөн мэдүүлнэ)
- ЦХМ-ын төсөл Монгол улсын тогтвортой хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулахыг тогтвортой хөгжлийн батлагдсан шалгуур үзүүлэлтүүдээр тайлбарлан харуулсан баримт бичиг(хэвлэмэл хоёр, электрон нэг хувийг өргөн мэдүүлнэ)
- Төсөлд оролцогчид батламж бичиг хүчингүй болгох нөхцөлтэй танилцсанаа хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан мэдэгдэл
- Товчооноос төслийг тогтвортой хөгжлийн шалгуураар үнэлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт материал

Товчооноос батламж бичиг олгох үйл явц:

- 1 Товчоо ажлын 5 хоногт батгаан өргөн мэдүүлсэн баримт бичгийн бүрэн бүтэн, шаардлага хангасан эсэхийг шалгана
- 2 Эхний шалгалтаар давсан төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргуулахаар ажлын 5 хоногт шинжээчдийн баг томилоно
- 3 ЦХМ-ын үндэсний товчооны вэб хуудсанд олон нийтийн санал авахаар ТББ-ийг 14 хоногийн хугацаатай байршуулах.
- 4 Товчоо нь шинжээчдийн дүгнэлт, олон нийтийн саналыг ТББ-ийн хамт Үнэлгээний Хороо (ҮХ)-ны бүх гишүүдэд хүргэж, ҮХ-ны хурал болох байрлал, цаг, огноог товлон зарыг цахим хуудсанд байршуулна.
- 5 Хурал болохоос 3 хоногийн өмнө Товчоонд мэдэгдсэн тохиолдолд ҮХ-ны хуралд ажиглагчаар оролцохыг хүссэн гурвадгач этгээд төсөлд оролцуулагчийг байлцуулан ҮХ-ны хуралд оролцож болно.
- 6 Үнэлгээний явцад төсөлд оролцогч шаардлагатай мэдээллийг хэр шуурхай өгч асуултад хэр хурдан хариулахаас хамааран товчооноос эцсийн шийдвэрийг төсөлд оролцогчдод ТББ хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30-60 хоногийн дотор мэдэгдэнэ.

Товчоо зөвхөн ТББ-т ноцтой өөрчлөлт гараагүй үед НҮБУАӨСК-ийн нарийн бичгийн дарга нарын газар, томилогдсон магадлах байгууллага (ТМБ), эсвэл ЦХМ-ын гүйцэтгэх зөвлөлөөс хүсэлт гаргасан тохиолдолд батламж бичгийг ҮХ-оор хэлэлцүүлэлгүйгээр шинэчлэн олгож болно. Ноцтой өөрчлөлт гэдгийг тухайн төслийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаанд гарсан нийгэм, эдийн засаг, байгаль орчинд нөлөөлхүйц өөрчлөлтийг хэлнэ.

Батламж бичиг олгох үйл явц (зайлшгүй)



* Ажлын өдөр

(3) Тогтвортой хөгжлийн шалгуур

ЦХМ-ын төсөл үнэлэх тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд

Байгаль орчны		
Уур амьсгалын өөрчлөлт (Малтмал түлшний хэрэглээг бууруулж буй эсэх, эрчим хүчний үр ашигийг дээшлүүлж буй эсэх, нүүрстөрөгч шингээж хуримтлуулж буй эсэх)	Орон нутгийн байгаль орчин (Агаар, ус, хөрс, бусад бохирдол, хаягдал)	Байгалийн нөөц баялагийн хэрэглээ (Нөөц баялагийг шавхагдуулж буй эсэх, биологийн төрөл зүйл)

Нийгмийн				
Ядуурлыг бууруулах (Ажлын байр бий болгож буй эсэх)	Эрх тэгш байдал (Орлогын тэгш хуваарьлалтад үзүүлэх нөлөө)	Хүний эрүүл мэнд	Нийгмийн үндсэн хэрэгцээг хангах (Эрчим хүч, ус, бохир ус)	Олон нийтийн экологийн боловсролыг сайжруулахад (сургалт, соён гэгээрүүлэх)

Эдийн засаг, технологийн		
Нөөцийн үр ашигтай, хэмнэлттэй зарцуулалт (Санхүүгийн нөөц, хүний нөөц, технологийн нөөц, оюуны нөөц)	Технологи, ноу-хау нэвтрүүлэх, дамжуулах	Дэд бүтэц бий болгож буй байдал (зам, тээвэр, эрчим хүчний шугам сүлжээ, дэд бүтэц, нийтийн үйлчилгээ)

Оноо	Нөлөөлөл
+2	Их эерэг нөлөөтэй
+1	Эерэг нөлөөтэй
0	Ямар нэг эерэг ба сөрөг нөлөөлөлгүй
-1	Сөрөг нөлөөтэй
-2	Их сөрөг нөлөөтэй

Үнэлгээний шалгуур бүрд ҮХ-ны гишүүдийн өгсөн онооны жинэлсэн дунджийг авч нийлбэр оноог тухайн шалгуурт өгсөн ҮХ-ны үнэлгээ гэж тооцно. Шалгуур үзүүлэлтийн гурван бүлэг асуудал тус бүрийн (байгаль орчинь, нийгэм, эдийн засаг) багана бүр дэх оноог нэмж эцсийн дүнг гаргана.

Тогтвортой хөгжлийн гурван бүлэг асуудлын аль нэг нь сөрөг үнэлгээ авсан тохиолдолд төслийг тухайн байдлаар нь батлахгүй бөгөөд төсөлд оролцогч нь тус асуудлыг эргэн хянаж шинэчлэх эсвэл сөрөг үр дагаврын эсрэг хариу арга хэмжээ авах шаардлагатай болно. Тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтийн бүлэг тус бүр эерэг оноотой байвал төслийг шууд батална. Хэрвээ бүлэг доторх аль нэг шалгуурын нийлбэр оноо сөрөг дүнтэй гарсан бол ҮХ тухайн шалгуурыг хэлэлцэж үзэх ба шаардлагатай тохиолдолд төсөлд оролцогчоос нэмэлт тодруулга авна. Тогтвортой хөгжлийн аль нэг бүлгийн нийлбэр үнэлгээ нь тэгтэй тэнцвэл үр дүн хангалтгүй гэж үзэн санал хураах аргад шилжинэ.

ЦХМ-тай холбогдолтой нэмэлт мэдээлэл

Монгол дахь эрх зүйн орчин

НҮБУАӨСК –д гарын үсэг зурсан өдөр	1992 оны 6 сарын 12
НҮБУАӨСК-ийг соёрхон баталсан өдөр	1993 оны 9 сарын 30
Киотогийн протоколыг соёрхон баталсан өдөр	1999 оны 12 сарын 15
Үндэсний товчоо байгуулагдсан өдөр	2004 оны 11 сарын 14

Эх сурвалж: <http://maindb.unfccc.int/public/country.pl?country=MN>

ЦХМ-ын ойжуулалтын төсөл хэрэгжүүлэх ой болон талбайд тавигдах шаардлага

Титэмийн бүрхэцийн доод хэмжээ	10%
Талбайн доод хэмжээ	1 га
Модны өндөрийн доод хэмжээ	2 м

ЦХМ-ын үндэсний товчооноос батламж бичгийг хүчингүй болгох нөхцөл

- | | |
|---|---|
| 1 | Товчооноос батламж бичиг олгосны дараа тухайн төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, дүрмийг зөрчсөн нь эсвэл өргөн мэдүүлсэн баримт бичигт бодит байдлыг тусгалгүйгээр санаатайгаар нуун дарагдуулсан юмуу бодит байдлыг гуйвуулсан гэдэг нь нотлогдсон тохиолдолд товчоо олгосон батламж бичгээ хүчингүй болгоно. |
|---|---|

Холбоо барих

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЦХМ-ын үндэсний товчоо
 НҮБ-ын гудамж 5/2, Засгийн газрын 2-р байр, Улаанбаатар, Монгол улс
 Утас: 976-11-320402 И-мэйл: info@cdm-mongolia.com Вэб хуудас: www.cdm-mongolia.com

Юрико Кояанаги, ДДБОСХ-ийн зах зээлийн механизмын хэсэг 2011 оны 12-р сар

Талархал

Монголын батламж бичиг авсан ЦХМ-ын төслүүдийн мэдээллийг БОАЖЯ-ны ЦХМ-ын үндэсний товчооноос бидэнд ирүүллээ. ЦХМ-ын танилцуулгын энэхүү хэвлэлд мэдээ, мэдээлэл, санал зөвлөмж өгч хамтарч ажилласан БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах алба болон ЦХМ-ын үндэсний товчоонд гүн талархлаа илэрхийлье.

НҮБУАӨСК-той холбоотой мэдээлэл

Монголын анхны үндэсний тайлан	2001 оны 11 сарын 1
Монголын хоёр дахь үндэсний тайлан	2010 оны 12 сарын 10

Эх сурвалж: НҮБУАӨСК

http://unfccc.int/national_reports/non-annex_i_natcom/items/2979.php

Монголын төвийн эрчим хүчний системийн ялгаралтын фактор

Бүс (нэгж: тнCO ₂ /МВт)	2009-2010	
	ОМ	ВМ
Төвийн эрчим хүчний систем	1.1501	1.0559

Эх сурвалж: ЦХМ-ын үндэсний товчоо <http://www.cdm-mongolia.com>